

НЭМЭЛТ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ
№ НАУ-ГТТА 2022-23

2022-09-12

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас **2699877** регистрийн дугаартай "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК, /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Г.Балжинням, нөгөө талаас **2082675** регистрийн дугаартай "Туушин" ХХК /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий захирал Н.Зоригт, /хамтад нь "Талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2017 оны "Нэмэлт ажил үйлчилгээ явуулах журам"-ыг үндэслэн Талууд дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Гүйцэтгэгч нь "Туушин" ХХК-ийн барьж байгуулах Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистикийн төвийн барилга байгууламжийг нэгдсэн системд холбох үеийн горимын тооцоог хийж гүйцэтгэх /цаашид "Гэрээт ажил" гэх/, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэ гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэ гэрээнд тусгагдаагүй бусад харилцааг Монгол улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Энэ гэрээний **Хавсралт-1-д** нь "Туушин" ХХК-ийн барьж байгуулах БЗД-ийн 11-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистикийн төвийн барилга байгууламжийг нэгдсэн системд холбох үеийн горимын тооцооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үнэ тариф"-ыг хавсаргав. Хавсралт-1 нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4. Энэ гэрээгээр гүйцэтгэсэн гэрээт ажил нь Талуудын оюуны өмч болох тул гуравдагч этгээдэд дамжуулах болон ашиглуулах тохиолдолд нөгөө Талын зөвшөөрлийг заавал авна.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын төлбөрийг төлсөн өдрөөс эхлэн ажлын 45 /дөчин тав/ хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Захиалагчаас хамаарсан болон Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Гэрээт ажлын нийт төлбөр нь татвар хураамж /НӨАТ/ багтсан дүнгээр **17,325,000.00 (арван долоон сая гурван зуун хорин таван мянга)** төгрөг байна.
- 3.2 Энэ гэрээний нийт төлбөрт Гүйцэтгэгчээс гэрээт ажлыг хийж гүйцэтгэх ажлын хөлс, шаардлагатай материал, ажилтны хөлс, бүх татвар, хураамж болон зардал багтсан болно.
- 3.3 Гэрээний төлбөрийг Захиалагч нь Гүйцэтгэгчид **17,325,000.00 (арван долоон сая гурван зуун хорин таван мянга)** төгрөгийг төгрөгийг нэхэмжлэхийг үндэслэн, Худалдаа хөгжлийн банкны 406002860 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.4 Гүйцэтгэгч нь Захиалагч гэрээт ажлын төлбөрийг бүрэн төлсөний дараа НӨАТ-ын баримтын бичилт хийнэ.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ТЭЗҮ, Нэгдсэн сүлжээтэй холбогдох схем, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын үндсэн тоноглолын өгөгдөл зэрэг бусад шаардлагатай мэдээллээр бүрэн хангана.
- 4.2 Хийгдэх ажлын хэмжээ өөрчлөгдөх, зогсоох шаардлага гарвал Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэх, гэрээнд заагдаагүй нэмэлт ажил гарвал Гүйцэтгэгчийн шаардлагыг хүлээн авч шийдвэрлэнэ.

- 4.3 Гүйцэтгэгчээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас ажлыг зогсоох, анх өгсөн техникийн өгөгдөл, анхдагч хэлхээний зураг схемд өөрчлөлт орж ажлыг дахин хийх шаардлага гарвал холбогдох зардал, ажлын хөлсийг Гүйцэтгэгчид нэмж төлнө.
- 4.4 Захиалагч нь зураг төслийн болон бусад холбогдох норм дүрэм, стандартыг Гүйцэтгэгч зөрчсөн болон чанарын гологдол гаргасан нь тогтоогдсон тохиолдолд уг доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.5 Захиалагч нь Гүйцэтгэгчээс гэрээт ажлын гүйцэтгэлийг албан тоот болон гэрээ дүгнэсэн актаар хүлээн авна.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1 Гүйцэтгэгч нь Захиалагчаас шаардагдах өгөгдөл, схем, мэдээллийг болон Захиалагчийн төлбөр төлсөн баримт зэргийг бүрэн хүлээн авсанаар гэрээт ажлыг эхэлнэ.
- 5.2 Гэрээт ажлыг холбогдох норм, дүрэм, стандартын дагуу чанартай гүйцэтгэж гэрээнд заасан хугацаанд багтаан Захиалагчид гэрээт ажлын гүйцэтгэлийг актаар хүлээлгэн өгнө.
- 5.3 Гэрээт ажлын явцад алдаа гарсан нь илэрч зураг төслийн ажлын явцад хүндрэл үүсгэвэл Гүйцэтгэгч өөрийн хүч хөрөнгөөр илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах үүрэг хүлээнэ.
- 5.4 Гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүн нь Захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэгдсэн, техникийн нөхцөл, зургийн даалгаврыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Захиалагчийн дахин тогтоосон хугацаанд өөрийн хөрөнгөөр мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэж гэрээт ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн актаар хүлээлгэн өгнө.
- 5.5 Захиалагчаас шилжүүлэн өгсөн аливаа баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 5.6 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд Захиалагчаас авсан техникийн үзүүлэлт, тооцоо, баримт материал зэргийг гэрээт ажил дууссаны дараа Захиалагчид хүлээлгэн өгнө.
- 5.7 Цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл авах эсвэл сунгуулах зорилгоор горимын тооцоо хийх тохиолдолд тооцоо дууссан тухай албан бичгийг захиалагчид хүргүүлнэ.
- 5.8 Гүйцэтгэгч нь горимын тооцоог ЭХЯ-ны техникийн нөхцөл олгох хурлаар хэлэлцүүлсний дараа албан бичгийн хамт тооцоог хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Захиалагч төлбөрийг гэрээнд заасан журмаар төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алданги төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гэрээний нийт үнийн дүнгийн 0.3 %-тай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.
- 6.3 Талуудын гэрээгээр хүлээсэн үүргээс үүсэх алданги төлөх дээд хэмжээ нь гэрээний нийт үнийн 10 %-аас хэтрэхгүй байна.
- 6.4 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг алдаатай алдаатай гүйцэтгэсний улмаас Захиалагчид хохирол учирсан тохиолдолд Гүйцэтгэгч нь үл маргах журмаар нөхөн төлнө.
- 6.5 Захиалагчийн буруугаас гэрээт ажлын гүйцэтгэл үр дүнгүй болж дахин горимын тооцоо хийх болсон тохиолдолд Захиалагч үл маргах журмаар Гүйцэтгэгчид дахин төлбөр төлнө.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ

- 7.1. Гүйцэтгэгч нь Захиалагчид гэрээт ажлыг албан бичгээр мэдэгдсэнээр энэ гэрээнд заагдсан хугацаанд ажлыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно.
- 7.2. Талууд гэрээт ажлыг гэрээний гүйцэтгэлийг хүлээлцэх актаар баталгаажуулна.

НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал гаргасан Тал нь албан бичгээр нөгөө талдаа саналаа хүргүүлнэ. Хүлээн авсан Тал нь ажлын 5 хоногт хариуг албан бичгээр хүргэнэ.
- 8.2 Нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан зөвөөрсөн тохиолдолд тус өөрчлөлтийг гэрээнд бичгээр үйлдэж оруулах бөгөөд Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

- 8.3 Энэ гэрээний нөхцлүүдийг зөрчсөн буюу гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлыг Талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 8.4 Гэрээнээс үүссэн маргааны зөвшилцөлийг эс зөвшөөрсөн Тал нь Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.5 Энэ гэрээг 2 /хоёр/ эх хувь үйлдэж, баталгаажуулах ба Талууд тус бүр нэг эх хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 8.6 Гэрээт ажлыг Талууд бүрэн хүлээлцэж, төлбөр тооцоог 100 хувь барагдуулсанаар гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК:

Гүйцэтгэх захирал

..... Т.Балжинням

Ерөнхий диспетчерийн албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч

..... Б.Баатар

СЭЗА-ны дарга

..... Т.Бямбажав

ЗЗЗА-ны дарга

..... Ц.Өнөрмаа

ГТТА-ны дарга

..... Х.Болд-Эрдэнэ

ЗЗЗА-ны ахлах мэргэжилтэн

..... Ч.Энхжаргал

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

..... Ч.Отгонбаатар

Гэрээний мэргэжилтэн

..... Д.Алимаа

Захиалагчийг төлөөлж:

"Туушин" ХХК-ийн

Ерөнхий захирал

..... Н.Зоригт

Туушин группын

Эрчим хүч интернэшнл ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

..... Д.Мягмарсүрэн

Гүйцэтгэгчийн хаяг:

17032. Улаанбаатар хот
Хан-уул дүүрэг, Чингисийн
Өргөн чөлөө. Засгийн газрын XIV байр
Утас: 70041371
Факс: 70043467
И-мэйл: ndc@ndc.energy.mn

Захиалагчийн хаяг:

14200. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Ерөнхий сайд Амарын гудамж – 15
Туушин компанийн төв байр
Утас: 976-11-320064, 312082, 325907
Факс: 976-11-322800, 325510
И-мэйл: info@tuushin.mn